

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН
ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 05 сарын 02 өдөр

Дугаар А/26

Сүмбэр сум

“Яргуй-2019” Хүүхдийн урлагийн наадамд
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Захиргааны ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 43 дугаар зүйлийн 43.1, 43.2, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 15.1.1, 15.1.4, Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөрийн 3.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр”-ийн хүүхэд бүрийг хөгжүүлэх таатай орчныг бүрдүүлж, хүүхдийн авьяас, чадварыг нээн хөгжүүлэх зорилгоор Аймгийн Засаг даргын нэрэмжит “Яргуй-2019” наадмыг зохион байгуулах ажлын удирдамжийг 1 дүгээр хавсралтаар, төсвийг 2 дугаар хавсралтаар баталсугай.

2. Аймгийн Засаг даргын нэрэмжит хүүхдийн урлагийн “Яргуй-2019” наадмыг амжилттай зохион байгуулахыг Хүүхдийн хөгжил, оролцоо хариуцсан мэргэжилтэн /Э.Урантунгалаг/-д үүрэг болгосугай.

3. Хүүхдийн урлагийн наадмын үйл ажиллагаанд зарцуулагдах 3 291 000 /гурван сая хоёр зуун ерөн нэгэн мянган/ төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжын зардлаас гаргахыг нягтлан бодогч /Д.Оюунцэцэг/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ц.ОЮУНБИЛЭГ

D:/Бичиг хэрэг /тушаал

421190042